ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

**АУДИТЫН КОД: ТӨА-2023/117/НА-СТА-ТШЗ**

**ТӨВ АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

Зуунмод 2023 он


Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582  Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463  Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ихмонгол хөлөг Аудит ХХК

Утас: 70001778  Цахим хаяг: info@imkaudit.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .......... 3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .......... 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .......... 6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .......... 8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .......... 10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан .......... 11
2.6 Аудит хийсэн улсын төсвийн гүйцэтгэлийн тайлан .......... 12
2.7 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан .......... 13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .......... 15
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .......... 15
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .......... 15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .......... 17
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .......... 17
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .......... 18
4. АУДИТЫН ТАЙЛАН .......... 20
4.1 Ерөнхий зүйл .......... 20
4.2 Материаллаг байдал .......... 20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .......... 20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .......... 20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .......... 21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .......... 22
4.5.1 Завсрын аудитын талаар .......... 22
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .......... 23
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .......... 24
5.1 Төлбөрийн акт .......... 24
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .......... 26

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ЗГ | Засгийн газар |
| ЭМЯ | Эрүүл мэндийн яам |
| ЭМС | Эрүүл мэндийн сайд |
| СНАГ | Санхүү-нийцлийн аудитын газар |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт Стандарт |
| УСБНЗСТОҮБ | Улсын секторын байгууллагуудын нийтлэг зорилготой санхүүгийн тайлагналын онолын үзэл баримтлал |
| НДХ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| НББББББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023·02·24 № 01/159

танай ______________-ны № ____________________-т

ТӨВ АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Г.УЯНГА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Төв аймгийн Баяндэлгэр сумын эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг өмнөх онтой харьцуулахад мөнгөн хөрөнгийн дансанд их хэмжээний өөрчлөлт орсон байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам”-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 16,779.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

**Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэл, бүртгэлийн суурь, бодлогын өөрчлөлт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тайлант хугацаанд өөрчлөлт ороогүй байна.

19020333

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд 1 удирдах, 14 гүйцэтгэх, 4 үйлчилгээний ажилтан, нийт 19 орон тоо батлагдсанаас 1 удирдах, 14 гүйцэтгэх, 4 үйлчилгээний албан тушаалд ажиллаж, батлагдсан бүтэц орон тоогоороо ажилласан байна.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 107,302,732.41 | 95,155,590.55 |
| 31 | МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ | 10,261,515.00 | 16,779,619.32 |
| 312 | Банканд байгаа бэлэн мөнгө | 10,261,515.00 | 16,779,619.32 |
| 3121 | Төгрөг | 10,261,515.00 | 16,779,619.32 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 10,261,515.00 | 16,779,619.32 |
| 33 | АВЛАГА | 57,353,000.00 | 15,136.17 |
| 33100 | Ажиллагсадтай холбогдсон авлага | - | 15,136.17 |
| 335 | Бусад авлага | 57,353,000.00 | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 57,353,000.00 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 39,688,217.41 | 78,360,835.06 |
| 351 | Түүхий эд материал | 6,013,778.60 | 8,856,601.64 |
| 35130 | Эм боох материал | 6,013,778.60 | 8,856,601.64 |
| 354 | Хангамжийн материал | 33,224,438.81 | 69,054,233.42 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 374,050.00 | 124,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 15,736,409.00 | 34,747,873.07 |
| 35440 | Түлш шатах тослох материал | 238,755.03 | 4,014,733.17 |
| 35460 | Хүнсний материал | 972,901.58 | 1,848,826.58 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 15,902,323.20 | 28,318,300.60 |
| 35600 | Мал, амьтад | 450,000.00 | 450,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 233,823,888.23 | 264,487,735.02 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 233,823,888.23 | 264,487,735.02 |
| 392 | Биет хөрөнгө | 210,247,888.23 | 240,911,735.02 |
| 39201 | Барилга, байгууламж | 154,118,053.30 | 154,118,053.30 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (21,737,878.76) | (29,200,505.00) |
| 39203 | Авто тээврийн хэрэгсэл | 31,910,000.00 | 31,910,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (31,627,666.83) | (31,910,000.00) |
| 39205 | Машин, тоног төхөөрөмж | 136,388,209.80 | 174,567,431.30 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (64,842,124.19) | (83,623,638.69) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 12,923,972.58 | 35,195,390.08 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (8,359,677.67) | (11,526,245.97) |
| 39209 | Зам гүүрийн барилга байгууламж | 2,225,000.00 | 2,225,000.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (750,000.00) | (843,750.00) |
| 393 | Биет бус хөрөнгө | 23,576,000.00 | 23,576,000.00 |
| 39301 | Программ хангамж | 446,950.00 | 446,950.00 |
| 39302 | Хасагдуулга | (446,950.00) | (446,950.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 23,576,000.00 | 23,576,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 341,126,620.64 | 359,643,325.57 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | 10,746,313.07 | 867,636.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 10,746,313.07 | 867,636.00 |
| 413 | Өглөг | 10,746,313.07 | 867,636.00 |
| 4136 | Бусад өглөг | 10,746,313.07 | 867,636.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 10,746,313.07 | 867,636.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 330,380,307.57 | 358,775,689.56 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 330,380,307.57 | 358,775,689.56 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан | 95,376,537.48 | 95,376,537.48 |
| 51101 | Өмч: -Төрийн өмч | 95,376,537.48 | 95,376,537.48 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 104,691,817.19 | 133,087,199.18 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 104,691,817.19 | 104,691,817.19 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 28,395,381.99 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 130,311,952.90 | 130,311,952.90 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 341,126,620.64 | 359,643,325.56 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 319,961,717.40 | 490,028,786.07 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 25,216,442.40 | 66,331,318.07 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 25,216,442.40 | 66,331,318.07 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 25,216,442.40 | 66,291,318.07 |
| 1200017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 5,500,000.00 | 41,335,339.00 |
| 1200018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 19,716,442.40 | 24,955,979.07 |
| 120009 | Бусад орлого | - | 40,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 75,674,175.00 | 423,697,468.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 219,071,100.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 42,716,155.00 | 1,250,000.00 |
| 131103 | ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс | - | 1,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи | 42,071,155.00 | 250,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 645,000.00 | - |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 26,587,000.00 | 42,132,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 26,587,000.00 | 42,132,000.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс | 6,371,020.00 | 380,315,468.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас | 6,371,020.00 | 380,315,468.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 279,986,282.47 | 461,633,404.08 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 279,986,282.47 | 461,633,404.08 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 279,986,282.47 | 458,291,324.08 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 161,315,183.25 | 251,216,071.65 |
| 210101 | Цалин | 142,682,033.36 | 203,749,780.64 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 12,076,536.11 | 37,669,293.01 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,240,780.89 | 1,467,000.00 |
| 210104 | Урамшуулал | 315,832.89 | 8,329,998.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 21,250,300.95 | 31,305,175.80 |

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 14,596,913.58 | 22,497,487.44 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 1,669,955.14 | 2,285,999.70 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 1,335,905.51 | 1,828,794.39 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 331,529.38 | 426,630.05 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 3,315,997.34 | 4,266,264.22 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 15,719,428.00 | 38,651,920.00 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 2,020,303.00 | 2,118,921.00 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 13,699,125.00 | 36,532,999.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 12,378,794.80 | 18,213,175.06 |
| 210401 | Бичиг хэргийн материал | 700,900.00 | 1,259,150.00 |
| 210402 | Тээвэр, шатахууны зардал | 8,179,279.00 | 14,473,921.86 |
| 210403 | Шуудан холбоо интернэтийн төлбөр | 675,000.00 | 900,000.00 |
| 210405 | Хог хаягдал устгах, цэвэрлэх | 2,823,615.80 | 1,580,103.20 |
| 2105 | Нормативт зардал | 28,642,708.00 | 59,716,206.96 |
| 210501 | Эм | 22,897,971.00 | 53,592,131.96 |
| 210502 | Хоол | 5,744,737.00 | 6,124,075.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 533,000.00 | 375,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 354,800.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 178,200.00 | 375,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 234,500.00 | 2,170,000.00 |
| 210702 | Дотоод томилолтын зардал | 234,500.00 | 2,170,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | - | 2,643,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 2,643,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 39,912,367.47 | 54,000,774.61 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,650,295.00 | 24,213,982.40 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 19,262,072.47 | 29,786,792.21 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | - | 3,342,080.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | - | 3,342,080.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 3,342,080.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II) | 39,975,434.93 | 28,395,381.99 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V) | - | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | - |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V) | - | - |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI) | 39,975,434.93 | 28,395,381.99 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 421,037,383.00 | 481,090,468.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 77,420.00 | - |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 77,420.00 | - |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 77,420.00 | - |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 77,420.00 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 420,959,963.00 | 481,090,468.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 300,097,300.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 71,253,155.00 | 1,250,000.00 |
| 131103 | ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс | - | 1,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн captured захи | 69,996,155.00 | 250,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,257,000.00 | - |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 41,541,800.00 | 42,132,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 41,541,800.00 | 42,132,000.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 8,067,708.00 | 437,668,468.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 8,067,708.00 | 437,668,468.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II) | 408,965,868.00 | 455,457,063.69 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 408,965,868.00 | 455,457,063.69 |
| 210 | БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 406,988,029.00 | 452,114,983.69 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 243,714,353.45 | 251,049,889.11 |
| 210101 | Үндсэн цалин | 160,896,728.67 | 160,037,664.17 |
| 210102 | Нэмэгдэл | 56,181,822.66 | 71,177,821.75 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 26,319,969.23 | 6,636,242.19 |
| 210104 | Үр дүнгийн урамшуулал | 315,832.89 | 13,198,161.00 |
| 2102 | Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл | 26,044,089.55 | 31,188,331.51 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 17,324,089.55 | 21,078,627.97 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 2,179,700.00 | 2,539,716.14 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 1,743,800.00 | 2,205,965.25 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 435,900.00 | 487,847.44 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 4,360,600.00 | 4,876,174.71 |
| 2103 | Байр ашиглалтай  холбоотой тогтмол зардал | 39,421,961.00 | 38,649,920.00 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 2,890,962.00 | 2,118,921.00 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 36,530,999.00 | 36,530,999.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 16,810,000.00 | 18,390,700.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,000,000.00 | 818,850.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,110,000.00 | 15,249,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 900,000.00 | 900,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,800,000.00 | 1,421,950.00 |
| 2105 | Нормативт зардал | 34,911,894.00 | 64,631,257.07 |
| 210501 | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 29,202,337.00 | 57,631,257.07 |
| 210502 | Хоол, хүнс | 5,709,557.00 | 7,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,890,000.00 | 22,028,600.00 |
| 210601 | Багаж техник хэрэгсэл | 1,240,000.00 | 4,833,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл | 3,500,000.00 | 15,695,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,150,000.00 | 1,500,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 382,500.00 | 2,170,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 382,500.00 | 2,170,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 39,813,231.00 | 24,006,286.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 39,813,231.00 | 24,006,286.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,977,839.00 | 3,342,080.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,008,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 1,008,000.00 | - |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 969,839.00 | - |
| 213301 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 969,839.00 | - |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | - | 3,342,080.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 3,342,080.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 12,071,515.00 | 25,633,404.32 |
| 4 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 1,810,000.00 | 19,115,300.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,810,000.00 | 19,115,300.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 1,810,000.00 | 19,115,300.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1,810,000.00 | 19,115,300.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (1,810,000.00) | (19,115,300.00) |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 10,261,515.00 | 6,518,104.32 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 10,261,515.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 10,261,515.00 | 16,779,619.32 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2021 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл | 95,376,537.48 | 132,378,897.52 | 54,916,475.77 | 282,671,910.77 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 95,376,537.48 | 132,378,897.52 | 54,916,475.77 | 282,671,910.77 |
| C04 | Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн | - | - | - | - |
| C05 | Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | - | - | (12,722,357.82) | (12,722,357.82) |
| C08 | 2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 95,376,537.48 | 130,311,952.90 | 104,691,817.19 | 330,380,307.57 |
| D01 | 2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 95,376,537.48 | 130,311,952.90 | 104,691,817.19 | 330,380,307.57 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 95,376,537.48 | 130,311,952.90 | 104,691,817.19 | 330,380,307.57 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | - | - | 28,395,381.99 | 28,395,381.99 |
| D09 | 2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 95,376,537.48 | 130,311,952.90 | 133,087,199.18 | 358,775,689.56 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 498,169,400.00 | 471,230,283.68 | 26,939,116.32 | 94.6 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 498,169,400.00 | 471,230,283.68 | 26,939,116.32 | 94.6 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 498,169,400.00 | 471,230,283.68 | 26,939,116.32 | 94.6 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 258,125,200.00 | 251,049,889.11 | 7,075,310.89 | 97.3 |
| 210101 | Үндсэн цалин | 163,125,200.00 | 158,575,702.17 | 4,549,497.83 | 97.2 |
| 210102 | Нэмэгдэл | 67,190,400.00 | 71,037,821.75 | (3,847,421.75) | 105.7 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 11,587,500.00 | 8,238,204.19 | 3,349,295.81 | 71.1 |
| 210105 | урамшуулал | 16,222,100.00 | 13,198,161.00 | 3,023,939.00 | 81.4 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 33,868,000.00 | 31,188,331.50 | 2,679,668.50 | 92.1 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,416,300.00 | 21,078,627.97 | 3,337,672.03 | 86.3 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,362,900.00 | 2,539,716.13 | (176,816.13) | 107.5 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,890,200.00 | 2,205,965.25 | (315,765.25) | 116.7 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 472,700.00 | 487,847.44 | (15,147.44) | 103.2 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,725,900.00 | 4,876,174.71 | (150,274.71) | 103.2 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 40,391,800.00 | 38,649,920.00 | 1,741,880.00 | 95.7 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,555,200.00 | 2,118,921.00 | 1,436,279.00 | 59.6 |
| 210302 | Түлш, халаалт | 36,538,100.00 | 36,530,999.00 | 7,101.00 | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 298,500.00 | - | 298,500.00 | - |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 18,950,000.00 | 18,390,700.00 | 559,300.00 | 97.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,000,000.00 | 818,850.00 | 181,150.00 | 81.9 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,250,000.00 | 15,249,900.00 | 100.00 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 900,000.00 | 900,000.00 | - | 100.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,800,000.00 | 1,421,950.00 | 378,050.00 | 79.0 |
| 2105 | Нормативт зардал | 69,507,500.00 | 69,384,944.07 | 122,555.93 | 99.8 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 62,507,500.00 | 62,384,944.07 | 122,555.93 | 99.8 |
| 210502 | хоол | 7,000,000.00 | 7,000,000.00 | - | 100.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 24,819,600.00 | 22,528,600.00 | 2,291,000.00 | 90.8 |
| 210601 | Багаж хэрэгсэл | 5,333,500.00 | 5,333,000.00 | 500.00 | 100.0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 16,836,100.00 | 15,695,600.00 | 1,140,500.00 | 93.2 |
| 210604 | Урсгал засвар | 2,650,000.00 | 1,500,000.00 | 1,150,000.00 | 56.6 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,500,000.00 | 2,170,000.00 | 330,000.00 | 86.8 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,500,000.00 | 2,170,000.00 | 330,000.00 | 86.8 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 50,007,300.00 | 37,867,899.00 | 12,139,401.00 | 75.7 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 50,007,300.00 | 37,867,899.00 | 12,139,401.00 | 75.7 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 498,169,400.00 | 481,090,468.00 | 17,078,932.00 | 96.6 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 42,132,000.00 | 42,132,000.00 | - | 100.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 42,132,000.00 | 42,132,000.00 | - | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 85,187,700.00 | 1,290,000.00 | 83,897,700.00 | 1.5 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 85,187,700.00 | 1,290,000.00 | 83,897,700.00 | 1.5 |
| 134 | НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС САНХҮҮЖИХ | 370,849,700.00 | 437,668,468.00 | (66,818,768.00) | 118.0 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 370,849,700.00 | 437,668,468.00 | (66,818,768.00) | 118.0 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 10,261,515.00 | (10,261,515.00) | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 16,779,619.32 | (16,779,619.32) | - |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 19 | 19 | - | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 10 | 10 | - | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 8 | 8 | - | 100.0 |
| 64 | ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО | 2140 | 2140 | - | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн улсын төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 456,037,400.00 | 432,440,363.68 | 23,597,036.32 | 94.8 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 456,037,400.00 | 432,440,363.68 | 23,597,036.32 | 94.8 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 456,037,400.00 | 432,440,363.68 | 23,597,036.32 | 94.8 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 257,600,500.00 | 250,909,889.11 | 6,690,610.89 | 97.4 |
| 210101 | Үндсэн цалин | 162,600,500.00 | 158,435,702.17 | 4,164,797.83 | 97.4 |
| 210102 | Нэмэгдэл | 67,190,400.00 | 71,037,821.75 | (3,847,421.75) | 105.7 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 11,587,500.00 | 8,238,204.19 | 3,349,295.81 | 71.1 |
| 210104 | Урамшуулал | 16,222,100.00 | 13,198,161.00 | 3,023,939.00 | 81.4 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 33,802,500.00 | 31,188,331.50 | 2,614,168.50 | 92.3 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,371,700.00 | 21,078,627.97 | 3,293,072.03 | 86.5 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,357,700.00 | 2,539,716.13 | (182,016.13) | 107.7 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,886,000.00 | 2,205,965.25 | (319,965.25) | 117.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 471,700.00 | 487,847.44 | (16,147.44) | 103.4 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,715,400.00 | 4,876,174.71 | (160,774.71) | 103.4 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 18,950,000.00 | 18,390,700.00 | 559,300.00 | 97.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,000,000.00 | 818,850.00 | 181,150.00 | 81.9 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,250,000.00 | 15,249,900.00 | 100.00 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 900,000.00 | 900,000.00 | - | 100.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,800,000.00 | 1,421,950.00 | 378,050.00 | 79.0 |
| 2105 | Нормативт зардал | 69,507,500.00 | 69,384,944.07 | 122,555.93 | 99.8 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 62,507,500.00 | 62,384,944.07 | 122,555.93 | 99.8 |
| 210502 | Хоол, хүнс | 7,000,000.00 | 7,000,000.00 | - | 100.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 23,669,600.00 | 22,528,600.00 | 1,141,000.00 | 95.2 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,333,500.00 | 5,333,000.00 | 500.00 | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 16,836,100.00 | 15,695,600.00 | 1,140,500.00 | 93.2 |
| 210604 | Урсгал засвар | 1,500,000.00 | 1,500,000.00 | - | 100.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,500,000.00 | 2,170,000.00 | 330,000.00 | 86.8 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,500,000.00 | 2,170,000.00 | 330,000.00 | 86.8 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 50,007,300.00 | 37,867,899.00 | 12,139,401.00 | 75.7 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 50,007,300.00 | 37,867,899.00 | 12,139,401.00 | 75.7 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 456,037,400.00 | 438,958,468.00 | 17,078,932.00 | 96.3 |
| 330002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 370,849,700.00 | 437,668,468.00 | (66,818,768.00) | 118.0 |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 85,187,700.00 | 1,290,000.00 | 83,897,700.00 | 1.5 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 85,187,700.00 | 1,290,000.00 | 83,897,700.00 | 1.5 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 16,779,619.32 | (16,779,619.32) | - |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 19 | 19 | - | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 10 | 10 | - | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 8 | 8 | - | 100.0 |
| 64 | ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО | 2140 | 2140 | - | 100.0 |

## 2.7 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 42,132,000.00 | 38,789,920.00 | (3,342,080.00) | 92.1 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 42,132,000.00 | 38,789,920.00 | (3,342,080.00) | 92.1 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 42,132,000.00 | 38,789,920.00 | (3,342,080.00) | 92.1 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 524,700.00 | 140,000.00 | (384,700.00) | 26.7 |
| 210101 | Үндсэн цалин | 524,700.00 | 140,000.00 | (384,700.00) | 26.7 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 65,500.00 | - | (65,500.00) | - |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 44,600.00 | - | (44,600.00) | - |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,200.00 | - | (5,200.00) | - |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,200.00 | - | (4,200.00) | - |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,000.00 | - | (1,000.00) | - |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,500.00 | - | (10,500.00) | - |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 40,391,800.00 | 38,649,920.00 | (1,741,880.00) | 95.7 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,555,200.00 | 2,118,921.00 | (1,436,279.00) | 59.6 |
| 210302 | Түлш, халаалт | 36,538,100.00 | 36,530,999.00 | (7,101.00) | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 298,500.00 | - | (298,500.00) | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,150,000.00 | - | (1,150,000.00) | - |
| 210604 | Урсгал засвар | 1,150,000.00 | - | (1,150,000.00) | - |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 42,132,000.00 | 42,132,000.00 | - | 100.0 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 42,132,000.00 | 42,132,000.00 | - | 100.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 42,132,000.00 | 42,132,000.00 | - | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | - | - | - | - |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 10,261,515.00 | 10,261,515.00 | - |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - | - | - |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 19 | 19 | - | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 10 | 10 | - | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 8 | 8 | - | 100.0 |
| 64 | ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО | 2140 | 2140 | - | 100.0 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төв нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо Эрүүл мэндийн салбарын тогтолцооны шинэчлэлийн хүрээнд оновчтой бодлого аргазүйгээр хангаж, мэргэшсэн чадварлаг хамт олон, дэвшилтэт технологиор тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулан, амьдралын зөв дадлыг иргэн бүрд хэвшүүлэх замаар хүн амын дундаж наслалтыг уртасгана.

Эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-т "Сум, тосгоны эрүүл мэндийн төв", Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлд эрүүл мэндийн төвийн чиг үүргийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай хуулийн 16.2, 16.7-д заасан үндсэн чиг үүргээс гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
- Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ, эх барихын тусламж, үйлчилгээ, сувилахуйн болон сэргээн засахын дагнасан тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэнийг холбогдох эрүүл мэндийн байгууллагад илгээх, эргэх холбоо тогтоох, тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах;
- Харьяа нутаг дэвсгэрийн хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх;
- Сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээ хийх;
- Түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 заасанчлан "Хот суурин газрын хүн амд төрөөс үзүүлэх өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлдэг" Эрүүл мэндийн сайдын харьяа байгууллага юм.

Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд тайлант онд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 01-ээс хэрэгжиж эхэлсэн.
- Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн "Төрийн хэмнэлтийн тухай" хууль /2022 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр батлагдсан./
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-д "Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн энэ хуулийн 21.1-д заасны дагуу ногдох албан татвар, 23.1-д заасны дагуу эдлэх хөнгөлөлтийг жилийн эцсийн тайлангаар эцэслэн тооцож тайлагнан, холбогдох татварыг төсөвт шилжүүлнэ";
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 203 дугаар тогтоол,
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай";
- "Дундаж цалин хөлс тодорхойлох журам"-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн А/49 дүгээр тогтоол;

Эмнэлэг, эрүүл мэндийн салбарт хийж байгаа шинэчлэл, үйл ажиллагаа, төсөв санхүүг дэмжсэн шийдвэрийг Засгийн газар, салбарын сайд, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс гаргаж мөрдүүлсэн байна. Үүнд:

- "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 09-ны өдрийн 107 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт"-аар "Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээ"-г тогтоосон;

- “Эмнэлэг, эрүүл мэндийн салбарт 2022 онд Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай, Цусны донорын тухай, Тамхины тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан ажилласан байна;
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/139 дүгээр “Журам батлах тухай” тушаал;
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн “Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай” 06 дугаар тогтоол;
- “Төрөөс эмийн зардлыг нь хариуцан амбулаториор эмчлэх өвчний жагсаалт, эм олгох үйл ажиллагааг зохицуулах журам батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2022 оны 8 дугаар сарын 09-ний өдрийн А/407 дугаар тушаал;
- ЭМСайдын 2022 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн А/216 дугаар тушаалаар “Төрийн эрүүл мэндийн байгууллагаас иргэнд үзүүлэх төлбөртэй үйлчилгээний жагсаалтыг баталсан;
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 01 дүгээр тогтоол;
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 2022 оны 05 дугаар тогтоол;
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 2022 оны 09, 14 дүгээр тогтоол;
- Сангийн сайд, ЭМС-ын 2022 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 49, А/118 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралтаар Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага иргэнд үзүүлэх төлбөртэй тусламж үйлчилгээний төлбөрийн жишиг жагсаалтыг, хоёрдугаар хавсралтаар Төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлж олсон орлогыг зарцуулах үлгэрчилсэн журмыг баталсан;
- ЭМС-ын 2022 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн А/216 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар “Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж үйлчилгээний журам”, хоёрдугаар хавсралтаар “Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт"-ыг тус тус баталсан;
- ЭМДҮЗ-ийн 2022 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын 2-т ”Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудаас үзүүлсэн үйлчилгээний нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн үлдэгдэл 20 хувь, сумын эрүүл мэндийн төвөөс үзүүлэх хэвтүүлэн эмчлэх, яаралтай тусламж, түргэн тусламж, шүд, амны хөндийн тусламж үйлчилгээний зардлыг эрүүл мэндийн байгууллагуудын 2022 оны 05 болон 06 дугаар сарын статистик тоон мэдээлэл дээр үндэслэн хяналт тавьж санхүүжүүлэх;
- ЭМДҮЗ-ийн 2022 оны 10 дугаар сарын 20-ний өдрийн 14 дүгээр тогтоолын 2-т ”Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудаас үзүүлсэн үйлчилгээний нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн үлдэгдэл 20 хувь, сумын эрүүл мэндийн төвөөс үзүүлэх хэвтүүлэн эмчлэх, яаралтай тусламж, түргэн тусламж, шүд, амны хөндийн тусламж үйлчилгээний зардлыг эрүүл мэндийн байгууллагуудын 2022 оны 7, 8, 9, 10 дугаар сарын статистик тоон мэдээлэл дээр үндэслэн хяналт тавьж санхүүжүүлэх;
- Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай Сангийн 2022 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал;

***Байгууллагын дотоод хяналтын талаар***

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын дагуу Эрүүл мэндийн төвийн даргын 2022 оны 3 дугаар сарын 23-ний өдрийн А/13 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар дотоод хяналтын багийн бүрэлдэхүүнийг 3 хүний бүрэлдэхүүнтэй томилж, 2 дугаар хавсралтаар “Алтанбулаг сумын эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын журам”-ыг баталсан байна. “Дотоод хяналт шалгалтын зорилго нь Эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, ЭМС-ын

тушаалд заавал мөрдөх стандарт, клиникийн удирдамж, байгууллагын дотоод журам, байгууллагын удирдлагын хуульд нийцсэн шийдвэрийн хэрэгжилт, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдалд хяналт тавьж илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах хууль, дүрэм журмыг мөрдүүлэхэд дотоод хяналтын зорилго оршино” гэж үйл ажиллагааг нь тодорхойлсон.

Төрийн хэмнэлтийн тухай, Шилэн дансны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт, төсвийн төлөвлөлт, зарцуулалтад хийх дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, хяналтаар илрүүлсэн зөрчил, дутагдлыг арилгахад чиглэсэн үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хүүхдийн төв сувиллын захирлын 2021 оны А/07 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг ашиглаж, санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэнтэй холбоотойгоор нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт холбогдох өөрчлөлтүүдийг тусгах шаардлагатай байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18,516.7 мянган төгрөгөөр буюу 5,4 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 10,261.5 | 16,779.6 | 6,518.1 |
| Авлага | 57,353.0 | 15.1 | (57,337.9) |
| Бараа материал | 39,688.2 | 78,360.8 | 38,672.6 |
| Үндсэн хөрөнгө | 233,823.9 | 264,487.7 | 30,663.8 |
| **Нийт хөрөнгө** | **341,126.6** | **359,643.3** | **18,516.7** |
| Өр төлбөр | 10,746.3 | 867.6 | (9,878.7) |

| | | | |
|---|---|---|---|
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 330,380.3 | 358,775.7 | 28,395.4 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **341,126.6** | **359,643.3** | **18,516.7** |

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, бараа материал үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс өмнөх оноос нэмэгдэж, авлага, өглөг буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 6,518.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.
2. Авлага дансны үлдэгдэл 57,337.9 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны авлагыг барагдуулсан нь гол нөлөө үзүүлсэн байна.
3. Бараа материал өмнөх оноос 38,672.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд тусгай зориулалттай материал, эм боох материал /Вакцин/-ыг Эрүүл мэндийн газраас үнэ төлбөргүй хүлээлгэн өгсөн нь гол нөлөө үзүүлсэн байна.
4. Үндсэн хөрөнгө өмнөх оноос 30,663.8 мянган төгрөгөөр нэмэгдэхэд ЭМГазраас үнэ төлбөргүй тоног төхөөрөмж хүлээлгэн өгсөн нь гол нөлөө үзүүлсэн байна.
5. Өглөг 9,878.7 мянган төгрөгөөр буурсан нь байгууллагад өгөх эмийн тооцоог төлснөөс шалтгаалсан байна.
6. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 28,395.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант жилийн үр дүн буурсан нь нөлөөлсөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 446,825.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 43,900.0 мянган төгрөг, нийгмийн даатгалын сангаас 15,045.0, нийт зарлагыг 505,770.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 58,496.8 мянган, ажил олгогчоос нийгмийн даатгалд олгох шимтгэл 13,625.0 мянган, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1,008.2 мянган, эд хогшил худалдан авах зардал 26,880.4 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 832.0 мянган төгрөгөөр нийт 100,842.4 мянган төгрөгөөр бууруулан, хангамж, бараа материалын зардал 640.0 мянган, нормативт зардлыг 48,757.5 мянган, дотоодын томилолтын зардал 1,000.0 мянган, бараа, үйлчилгээний бусад зардал 42,844.3 мянган төгрөг, нийт 93,241.8 мянган төгрөгөөр өсгөж 498,169.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төв нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйтэй холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр эрүүл мэндийн даатгалын сангаас 370,849.7 мянган төгрөгийг, орон нутгийн төсвөөс 42,132.0 мянган төгрөгийг, туслах үйл ажиллагааны орлогоос 85,187.7 мянган төгрөгийг нийт 498,169.4 мянган төгрөгийг бүрдүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 437,668.5 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 42,132.0 мянган төгрөгийн, нэмэлт санхүүжилтээр 1,290.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 471,230.3 мянган төгрөг буюу 94,6 хувьтай байгаа нь цалин хөлсний зардлыг 7,075.3 мянган, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 2,679.7 мянган, байр ашиглалттай холбоотой зардал 1,741.9 мянган, хангамжийн материалын зардал 559.3 мянган, нормативт зардлыг 122.6 мянган, эд хогшил худалдан

авах зардал 2,291.0 мянган, албан томилолтын зардал 330.0 мянган, бараа үйлчилгээний бусад зардал 12,139.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэж, зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээ 26,939.1 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөг/*

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| | Улсын төсвөөс санхүүжих | | | | |
| 1 | 80302- нэг иргэнд ноогдох норматив | 173,562.9 | 166,548.6 | 7,014.3 | 96.0 |
| 2 | 81603-үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ | 197,286.8 | 183,337.6 | 13,949.2 | 92.9 |
| 3 | 83603- Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан | 85,187.7 | 82,554.2 | 2,633.5 | 96.9 |
| **Дүн** | | **456,037.4** | **432,440.4** | **23,597.0** | **94.8** |
| | Орон нутгийн төсвөөс | | | | |
| 1 | 80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 41,541.8 | 38,649.9 | 2,891.9 | 93.0 |
| 2 | 80112-Нийтлэг үйлчилгээ | 590.2 | 140.0 | 450.2 | 23.7 |
| **Дүн** | | **42,132.0** | **38,789.9** | **3,342.1** | **92.1** |
| **Нийт дүн** | | **498,169.4** | **471,230.3** | **26,939.1** | **94.6** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Баяндэлгэр сумын эрүүл мэндийн төв нь Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны 1/318 тоот “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийн 2-т “Гүйцэтгэлээр санхүүжилт авч буй төсвийн байгууллагууд нэмэлт дансыг ашиглахгүй, хуучин ашиглаж байсан үндсэн дансаар орон нутгийн санхүүжилт авч байгаа тул тус тус дансанд байгаа урьд оны үлдэгдлийг “урьд оны үлдэгдлээс санхүүжих-3000006” ангиллаар үндсэн дансанд шилжүүлж “Нэмэлт-Дээд шатны төсвөөс хуваарилсан /83603/” зориулалтын дагуу “Төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны зориулалтын дагуу “Төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого 120010” ангилалд орлого хуваарилан зарцуулах” гэж заасны дагуу нэмэлт санхүүжилтийн дансаар ажил, гүйлгээ гараагүй тул нэмэлт санхүүжилтийн тайлан бэлтгэгдээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баяндэлгэр сумын эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, анхан шатны баримтын бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төсвийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж зарцуулах, төсвийн хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Ариунбат, аудитор Д.Буянравжих, О.Эрдэнэчимэг, шинжээч Б.Ган-Эрдэнэ, Т.Оюун, аудитын менежер Б.Батцэцэг, аудиторын туслах З.Ариунцэцэг, Г.Ариунболд нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын мэргэжилтэн С.Сожидмаа, захирал С.Тунгалаг, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, Дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баяндэлгэр сумын эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ихмонгол хөлөг Аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 7 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 1.0 хувиар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Шинэчлэн тогтоосон материаллаг байдлыг Төв аймгийн Баяндэлгэр сумын эрүүл мэндийн төвийн 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 461,633.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4,616.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон материаллаг байдлын 70.0 хувиар буюу 3,231.4 мянган төгрөгөөр тогтоов.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор цалин хөлсний зардлыг 7,075.3 мянган, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 2,679.7 мянган, байр ашиглалттай холбоотой зардал 1,741.9 мянган, хангамжийн материалын зардал 559.3 мянган, нормативт зардлыг 122.6 мянган, эд хогшил худалдан авах зардал 2,291.0 мянган, албан томилолтын зардал 330.0 мянган, бараа үйлчилгээний бусад зардал 12,139.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 155 мэдээлэл байршуулахаас 132 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 22 удаагийн мэдээлэл хугацаа хоцроож, 1 мэдээллийг байршуулаагүй, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 12 удаагийн 229,516.8 мянган төгрөгийн орлого, 5 удаагийн 59,151.2 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг байршуулаагүй, мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын журналд байхгүй болон цалингийн зардлаас бусад 5 сая төгрөг хүрэхгүй 1 удаагийн 18,117.8 мянган төгрөгийн орлогын гүйлгээг байршуулж, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн 7 удаагийн 66,877.2 мянган төгрөгийн шийдвэрийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр'', Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4-т "Энэ хуулийн 3.1.3, 3.1.4-т заасан хуулийн этгээдийн тухайн жилд төлсөн бүх төрлийн албан татвар, төлбөр, хураамж, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн мэдээлэл, төрийн эрх бүхий байгууллагаас тухайн хуулийн этгээдэд ногдуулсан аливаа акт, албан шаардлага, зөрчлийн хэрэг, тэдгээрийн шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг олон нийт танилцах боломжтой хэлбэрээр байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулна." гэж заасныг тус тус зөрчиж, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**<u>Шийдвэрлэсэн нь</u>:** Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

1. Дотоод хяналтын үйл ажиллагаа нь зөвхөн эрүүл мэндийн үндсэн үйл ажиллагаанд чиглэгдсэн, санхүү, шилэн данс, нягтлан бодох бүртгэл, төсвийн тухай, төрийн болон орон нутгийн өмчийн тухай, төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийдэггүй, ажилтнууд нь дотоод хяналтын талаар сургалтад хамрагдаагүй, дотоод хяналтын талаар зохих мэдлэг эзэмшээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д "Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;",

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно." заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**<u>Шийдвэрлэсэн нь:</u>** Дотоод аудитын бүрэлдэхүүнийг сайжруулах, холбогдох заавар аргачлалаар хангаж ажиллах зөвлөмж өгөв.

2. Байгууллагын мөрдөж буй НБББББ-нь шинэчлэн батлагдсан УСНББОУС, хууль, тогтоол, тушаал зааврууդыг тусгаагүй, байгууллагын удирдлагын тушаал шийдвэрээр батлаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг", 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.2-т Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;" заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**<u>Шийдвэрлэсэн нь:</u>** НБББББ-ийг стандарт, хууль, тогтоомж, тушаал, заавар, дүрэм журамд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, баталж мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

3. Шалгагдагч байгууллагын худалдан авсан хөрөнгө, материалын дүнг, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим системд бүртгэсэн дүнтэй тулгахад 11 иргэн, байгууллагын 22,466.4 мянган төгрөгийн төлбөрийн баримт дутуу байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6.”Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.”, заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**<u>Шийдвэрлэсэн нь:</u>** Нягтлан бодох бүртгэлд төлбөрийн цахим баримтгүй ажил гүйлгээ бүртгэхгүй байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудитыг хэрэгжүүлээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчилд давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр бүрэн хэрэгжүүлсэн гэж хүргүүлсэн боловч гүйцэтгэлийн үе шатанд шалгахад 66,7 хувийг хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 2 | - | 2 | | **100.0** |
| Албан шаардлага | 1 | - | 1 | - | **-** |
| **Нийт дүн** | **3** | **-** | **3** | **-** | **66.7** |

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар худалдан авах ажиллагааны хэрэгжилт, шилэн дансны хэрэгжилт авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 191,719.7 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 2 алдаа[1] илэрснийг аудитын явцад 191,719.7 мянган төгрөгийн алдааг залруулав. Үүнд:

1. Цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлийг ерөнхий журналын цалингийн зардалтай тулган шалгахад 50,347.6 мянган төгрөгөөр, гарт олгосон мөнгөн дүн 775,078.3 мянган төгрөгөөр, нийт 51,122.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг;
2. Хувь хүний орлогын албан татварын тайланг цахим тайланд илгээхдээ цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлийн дүнгээс 19 хүний 140,597.1 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна.” гэж заасныг үндэслэн залруулав.

Аудитаар нийт 348.3 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 348.3 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоов.

### 5.1 Төлбөрийн акт

1. Цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлийг давтан тооцоолоход ажил хавсарсны нэмэгдлийг 1 ажилтанд 7 дугаар сард 102.3 мянган төгрөгөөр илүү тооцоолж олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3-т "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

2. Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг 6 хүнд 74.0 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон байна. Энэ нь Татварын ерөнхий газрын 2019 оны А/261 тоот тушаалын хавсралтын 4.4.10-т "Тухайн тайлант жилийн 12 сард бүрэн тухайн байгууллагад харьяалагдаж ажилласан ажилтанд Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.10-д заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг мөн хуулийн 27.10-д заасны дагуу жилийн эцэст өссөн дүнгээр тооцож, зөрүүг залруулж тайлагнана.", 4.4.20-т "Тайлант жилийн 12 сарын турш тухайн байгууллагад харьяалагдаж ажиллаагүй ажилтныг Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.10-д заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг суутгагч өссөн дүнгээр тооцох, зөрүүг залруулах үүрэг хүлээхгүй." гэж заасныг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3-т "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

3. Албан томилолтоор ажилласан давхардсан тоогоор 41 ажилтанд хоолны олговор 60.0 мянган төгрөгийг нэмж, томилолтын зам хоногийн зардлыг 112.0 мянган төгрөгөөр илүү тооцож, нийт 172.0 мянган төгрөгийн томилолтын зардлыг илүү олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т "Албан томилолтоор

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно.", 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтын 2.4-т "Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно." гэж заасныг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

Дээрх төлбөрийн актын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 15-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлийг ерөнхий журналын цалингийн зардалтай тулган шалгахад 50,347.6 мянган төгрөгөөр, гарт олгосон мөнгөн дүн 775,078.3 мянган төгрөгөөр, нийт 51,122.6 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. | 1 | 51,122.6 | - | - | 1 | 51,122.6 | 1 | 51,122.6 | - | - | - | - |
| Хувь хүний орлогын албан татварын тайланг цахим тайланд илгээхдээ цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлийн дүнгээс 19 хүний 140,597.1 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна. | 1 | 140,597.1 | - | - | 1 | 140,597.1 | 1 | 140,597.1 | - | - | - | - |
| **Дүн** | **2** | **191,719.7** | - | - | **2** | **191,719.7** | **2** | **191,719.7** | - | - | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлийг давтан тооцоолоход ажил хавсарсны нэмэгдлийг 102.3 мянган төгрөгөөр илүү тооцоолж олгосон байна. | 1 | 102.3 | 1 | 102.30 | - | - | - | - | - | - | - | - |
| Тайлант оны эцэст хувь хүний орлогын албан татварын зөрүүг тооцоолоогүй улмаас 6 ажилтанд 74.0 мянган төгрөгийн татварын хөнгөлөлтийг илүү тооцож олгосон байна. | 1 | 74.0 | 1 | 74.00 | - | - | - | - | - | - | - | - |
| Тайлант онд давхардсан тоогоор 41 ажилтанд томилолтын зардлыг олгохдоо 60.0 мянган төгрөгийн хоолны олговрыг давхардуулж, 112.0 мянган төгрөгийн томилолтын зам хоногийг илүү, нийт 172.0 мянган төгрөгийг илүү олгожээ. | 1 | 172.0 | 1 | 172.00 | - | - | - | - | - | - | - | - |
| **Дүн** | **3** | **348.3** | **3** | **348.3** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 155 мэдээлэл байршуулахаас 132 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 22 удаагийн мэдээлэл хугацаа хоцроож, 1 мэдээллийг байршуулаагүй, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 12 удаагийн 229,516.8 мянган төгрөгийн орлого, 5 удаагийн 59,151.2 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг байршуулаагүй, мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын журналд байхгүй болон цалингийн зардлаас бусад 5 сая төгрөг хүрэхгүй 1 удаагийн 18,117.8 мянган төгрөгийн орлогын гүйлгээг байршуулж, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн 7 удаагийн 66,877.2 мянган төгрөгийн шийдвэрийг байршуулаагүй байна. | 1 | 373,663.0 | - | - | 1 | 373,663.00 | - | - |
| **Дүн** | **1** | **373,663.0** | **-** | **-** | **1** | **373,663.0** | **-** | **-** |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| 2022 онд хийгдсэн дотоод аудитын үйл ажиллагаа нь зөвхөн эрүүл мэндийн үйл ажиллагаанд чиглэгдсэн, санхүү, шилэн данс , нягтлан бодох бүртгэл, төсвийн тухай, төрийн болон орон нутгийн өмчийн тухай, төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийдэггүй, санхүүгийн мэргэжлийн ажилтан дотоод хяналтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдоогүй, ажилтнууд нь дотоод хяналтын талаар сургалтад хамрагдаагүй, дотоод хяналтын талаар зохих мэдлэг эзэмшээгүй, дотоод хяналтын ажиллах журамгүй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - |
| Шалгагдагч байгууллагын худалдан авсан хөрөнгө, материалын дүнг, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим системд бүртгэсэн дүнтэй тулгахад 11 иргэн, байгууллагын 22,466.4 мянган төгрөгийн төлбөрийн баримт дутуу бүртгэгдсэн байна. | 1 | - | - | - | - | - | 1 | 22,466.4 |
| Байгууллагын мөрдөж буй НБББББ-нь шинэчлэн батлагдсан УСНББОУС, хууль, тогтоол, тушаал зааврууды тусгаагүй, байгууллагын удирдлагын тушаал шийдвэрээр батлаагүй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - |
| **Дүн** | **3** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **3** | **22,466.4** |
| **Нийт дүн** | **4** | **373,663.0** | **-** | **-** | **1** | **373,663.0** | **3** | **22,466.4** |